



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 12 сарын 15 өдөр

Дугаар А/768

Булган сум

Эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1; Авто замын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.9, аймгийн Онцгой комиссын 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн VII хурлын тэмдэглэлийн 1.8, 4.1 дэх хэсэг, Булган аймаг, “Эрдэнэт үйлдвэр” Төрийн өмчит үйлдвэрийн газрын 2025 оны хамтын ажиллагааны төлөвлөгөөний 9 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хангал-Хялганат чиглэлийн орон нутгийн чанартай 53.6 км авто замын ашиглалт, хамгаалалт арчилгааны ажилд зориулан Хангал сумын Хялганат тосгоны захирагч (П.Отгондаваа)-д 50,000,000 (тавин сая) төгрөгийг захиран зарцуулах эрхийг олгосугай.

2. Авто зам засварын ажилд зарцуулах эрх олгогдсон хөрөнгийг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд зориулалтын дагуу зарцуулж, ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, тайлагнахыг Хангал сумын Хялганат тосгоны захирагч (П.Отгондаваа)-д үүрэг болгосугай.

3. Дээрх ажлыг гүйцэтгэхэд шаардагдах хөрөнгийг Аймгийн Засаг даргын тамгын газрын нэмэлт санхүүжилтийн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

